

АНУ-ЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ТӨСВИЙНТОГТОЛЦОО (An analysis of school funding system in USA)

Г.Өлзийсайхан, доктор, МУБИС

Abstract: The purpose of this research is to study the USA grant of local education and make a suggestion to Mongolian grant of local education. The research is completed within the framework of grant and distribution of the project. According to the results of a recent survey, we could say that general education system is referred to the local education, in order that the state and local general education is strongly essential in grant and distribution of the project. Grant and distribution of the general education is divided into the USA, state and local and school district. Also, the grant of the project consists of the property tax revenues. The aim of the grant and distribution of the general education of government of US is to provide the right to acquire education and it is occupied no more than 10 percent of the general education projects. State and local make the rest of the share and sharing grant of the general education is based on the equal term. Therefore, states use various methods to share equally.

Түлхүүр үг: боловсролын төсөв, төсвийн бүрдүүлэлт, төсвийн хуваарилалт

Удиртгал

Манай улс боловсролын тогтолцоог дэлхийн жишигт нийцүүлж, 12 жилийн хугацаатай болгож, ирээдүйн монгол иргэнийг бэлтгэхийн тулд чанарын олон шинэчлэлийг боловсруулан хэрэгжүүлж байна. Үүний цаана орхигдуулж болохгүй асуудал бол ерөнхий боловсролын санхүүжилтийн механизм юм. Боловсролын зорилтыг хангах санхүүжилтийн механизм нь тэгш байдлыг хангах, боловсрол олгох, үр ашгийг хангах гэсэн гурван үүрэгтэй байдаг(Росс, Ливакик, 1999¹). Мөн тэгш байдал, үр ашгийн цаана хариуцлагын асуудал давхар яригдаж байдаг байна.

(Эхэлж бүтэн бичээд ард нь хаалтанд товчлолыг өгдөг гэж би бичсэн дээ!!!) БХАН (Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг) (2013)-ны судалгаа нь манай орны ерөнхий боловсролын санхүүжилтийн бодлого тэгш байдлыг хангахад биш, үр дүн, хариуцлагад суурилсан хандлагад чиглэсэн ч биш, харин тэгш бус байдлыг аажмаар нэмэгдүүлэх чиглэлд хэрэгжиж байна гэж дүгнэсэн байна. Мөн өрх гэрүүд орлогын

түвшнээсээ хамааран хүүхдийн боловсролд эрс ялгаатай хөрөнгө оруулалт хийж байна гэжээ. Энэ нь манай орны ерөнхий боловсролын санхүүжилтийн тогтолцоонд өөрчлөх, сайжруулах зүйл багагүй байгааг харуулж байна. Гэтэл энэ талаарх суурь судалгаа ховор, байгаа ганц нэг нь бодлогын түвшинд хийгдэж, энэ нь олон нийтэд хүртээмжгүй байна.

Тиймээс АНУ-ын ерөнхий боловсролын төсвийн бүрдүүлэлт, хуваарилалтын тогтолцооны талаар судалж, манай оронд ашиглаж болох арга замыг илрүүлэх нь энэ судалгааны зорилго юм.

Судалгаанд боловсролтой холбоотой хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, байгууллагуудын тайлан, судлаачдын бүтээл, статистикийн мэдээллүүдийг ашиглалаа. Америкийн ерөнхий боловсролын төсвийг судлахдаа бүрдүүлэлт, хуваарилалт нь хэрхэн хийгддэг, Засгийн газар, орон нутгийн үүрэг, оролцоо зэрэг үзүүлэлтийг ашиглалаа.

Америкийн боловсролын тогтолцоо

Энэ хэсэгт Америкийн Нэгдсэн Улсын боловсролын удирдлагын тогтолцоо, Засгийн газар, муж, сургуулийн түвшний удирдах байгууллагуудын үүргийн талаар дурдах болно.

АНУ нь 51 муж улсаас бүрдсэн холбооны улс юм. Тиймээс холбооны улс, муж улс, орон нутгийн зүгээс гүйцэтгэх үүрэг салбар салбарт өөр өөр байдаг байна. Үүний нэг жишээ нь ерөнхий боловсрол юм. Америкт ерөнхий боловсрол нь муж улсаас үзүүлэх үйлчилгээнд багтдаг(Каплан, Овингс, 2010²) ба орон нутаг буюу сургуулийн дүүрэг³ энэхүү үйлчилгээг хэрэгжүүлдэг байна. Гэсэн ч холбооны улс боловсролыг тэргүүлэх салбарт тооцон анхаарлын төвдөө байлгадаг ажээ. Мөн холбооны улсын Засгийн газрын боловсролын бодлого нь боловсролд тэгш хамруулах, боловсролын хүртээмжид гол анхаарлаа хандуулдаг байна.

Боловсролын удирдлагын тогтолцоо нь төрийн удирдлагаас бие даасан, орон нутагт төвлөрсөн байдаг ба энэ нь сургуулийн дүүрэг юм. Энэ нь засаг захиргааны нэгж биш, зөвхөн боловсролын үйлчилгээг хүргэхэд бүс нутгийг зохион байгуулсан нэг хэлбэр бөгөөд зарим дүүрэг нь засаг захиргааны нэгжтэйгээ давхцах тохиодол

¹ Kaplan & Owings
² school district

¹ Ross & Levacic

байдаг байна.

Холбооны улсын хэмжээний боловсролын тогтолцоо гэж байдаггүй, боловсролын тогтолцоог бүрдүүлэх эрхийг муж улс эдэлдэг ажээ. Тиймээс муж улсуудын боловсролын тогтолцоо нь харилцан адилгүй, дийлэнх нь 8-4, 6-3-3, 6-6 гэсэн 12 жилийн тогтолцоотой. Суурь боловсролын

хугацаа мөн адил муж болгондоо өөр ба дийлэнх нь 9-12 жил байдаг байна.

АНУ-ын ерөний боловсролын зарим үзүүлэлтийг хүснэгт 1-д харуулав. Нийт 18,200 сургуулийн дүүрэг байдаг ба 120,406 сургууль үйл ажиллагаа явуулж, 53,594,280 суралцагч сурч байна.

Хүснэгт 1. АНУ-ын ерөнхий боловсролын зарим үзүүлэлт ('12-'13 оны хичээлийн жил)

	Улсын	Хувийн
Сургуулийн дүүрэг		18,200
Сургуулийн тоо	97,717	22,689
Сурагчийн тоо	49474030-301226	4684896-263420

Эх сурвалж: Боловсролын статистикийн үндэсний төв¹
<http://nces.ed.gov/ccd/elsi/tableGenerator.aspx?savedTableID=16589>
<http://nces.ed.gov/ccd/elsi/tableGenerator.aspx?savedTableID=16591>
 * Хувийн сургуулийн мэдээлэл нь '11-'12 оны хичээлийн жилийнх юм.

Сургуулийн хэв шинж олон янз ба сургалтын хугацаанаас хамаарч цэцэрлэгээс эхлээд ахлах анги төгсөх хүртэлх үйлчилгээ үзүүлдэг сургууль, бага сургууль, дунд сургууль, ахлах сургууль гэж ангилдаг. Эдгээрийг дотор нь үйл ажиллагааны онцлогоос нь хамаарч жирийн¹, мэргэжил олгох², тусгай хэрэгцээт³, хувилбарт сургууль⁴ гэж ангилдаг байна. Хувилбарт сургууль нь улсын боловсролын тогтолцооноос гадуур чөлөөт хөтөлбөрөөр сургалтаа явуулдаг бөгөөд суралцагч, эцэг эхийн сонголтыг эн тэргүүнд хүндэтгэн, тусгай хөтөлбөрөөр үйл ажиллагаагаа явуулдаг аж. Ийм сургуульд жирийн сургуулийн нөхцөл байдалд дасаж чадахгүй завсардсан, өөр сургалтын хөтөлбөрөөр хичээллэх сонирхолтой зэрэг олон янзын шалтгаантай хүүхдүүд суралцах нь элбэг ажээ. 2013 оны байдлаар 6,300 гаруй сургууль энэ ангилалд хамаарч байна. Мөн улсын сургуулийн зарим нь чартер сургууль⁵ гэсэн хэв шинжтэй ба ийм сургуулийн тоо 6,278 байна. Чартер сургууль нь улсын төсвөөр үйл ажиллагаа явуулдаг ч, бие даасан эрхтэйгээр ажилладаг байна. Төрөлжсөн сургалттай сургууль⁶ гэж байдаг ба энэ нь тусгай чиглэлээр гүнзгийрүүлсэн сургалт явуулна.

Мөн өмчийн хэлбэрийн хувьд улсын болон хувийн гэж ангилна. Хувийн сургууль нь дотроо нь шашны болон шашны бус гэж хуваагдана. Нийт хувийн сургуулийн 74 орчим хувийг шашны

сургууль эзэлж, 29 төрлийн шашны чиглэлээр сургалтаа явуулдаг байна.

Америкийн ерөнхий боловсролын төсвийн тогтолцоо

1. Төсвийн бүрдүүлэлт

Америк улсын ерөнхий боловсролын төсвийн тогтолцоо нь Холбооны улсын Засгийн газар, муж улсын Засгийн газар, орон нутаг (хот, сургуулийн дүүрэг) гэсэн гурван түвшинд хуваагддаг аж. Энэ гурван субъект нь тус тусдаа татварын орлого бүрдүүлэх эрхтэй байна. (Худалдааны хэлтэс, 2013⁷). Ерөнхий боловсролын төсвийн хувьд хамгийн чухал үүргийг мужийн Засгийн газар, орон нутаг гүйцэтгэнэ. АНУ нь төр ба шашин тусгаар байх зарчмын⁸ дор хувийн сургуулиудыг улсын төсвөөс санхүүжүүлдэггүй юм байна (Ким, 2014⁹). Харин эмзэг бүлгийн хүүхдийн зарим зардлыг л санхүүжүүлдэг аж. Тиймээс энэхүү судалгаанд яригдаж байгаа төсөв нь улсын сургуулийн төсвийн хүрээ юм. 2013 оны санхүүгийн жилд ерөнхий боловсролын нийт төсөв (хөрөнгийн зардал ороогүй) 597.9 тэрбум доллар, үүний 9.1%-ийг холбооны улсын Засгийн газар, 45.6%-ийг муж улсуудын Засгийн газар, үлдсэн 45.3%-ийг орон нутгаас бүрдүүлжээ

Холбооны улсын Засгийн газрын санхүүжилтийн эрх зүйн үндэс нь 1965 онд батлагдсан “Бага дунд боловсролын тухай хууль”¹⁰ юм. Холбооны улсын Засгийн газар татварын

1 regular school
 2 vocational school
 3 special education school
 4 alternative school
 5 charter school
 6 magnet school

7 US. Department of Commerce
 8 separation between church and state
 9 Kim
 10 Elementary and Secondary Education Act

орлогоор боловсролын төсвийг бүрдүүлдэг ба нийт төсөвт эзлэх хувь нь бага, үүнийгээ дагаад Засгийн газрын үүрэг хязгаарлагдмал байдаг байна. Татварт орлогын албан татвар, нийгмийн даатгалын татвар багтдаг ба орлогийн татвар дийлэнх хувийг эзэлдэг аж. Харин муж улс ерөнхий боловсролыг санхүүжүүлэх эрх зүйн үндэс нь тухайн муж улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж юм. Өмнө нь ерөнхий боловсролын төсвийн дийлэнх хувийг орон нутагас бүрдүүлдэг байсан нь орон нутаг хоорондын боловсролын ялгааг бий болгож байжээ. Энэхүү ялгааг багасгахын тулд боловсролын төсөв бүрдүүлэхэд муж улсын оролцоог нэмэгдүүлж, 2013 оны байдлаар муж улс боловсролын төсвийн 45.6%-ийг бүрдүүлэх болжээ.

Муж улс боловсролын төсвийг татварын орлогоор бүрдүүлдэг аж. Үүний дийлэнх хувийг орлогын болон өртөгийн татвар¹¹ (гаалийн, хэрэглээний, хөрөнгийн г.м.), хураамж ба орлогын татвар эзэлдэг байна. Зарим мужийн хувьд орлогын татварын орлого орон нутгийн орлогод орох тохиолдол байдаг байна.

Орон нутаг боловсролын төсвийг бүрдүүлэх эх үүсвэр нь гаалийн хийгээд хэрэглээний татвар хураамж байдаг бол сургуулийн дүүргүүдийн хувьд хөрөнгийн татвар дийлэнх хувийг эзэлдэг ажээ. Энэ нь боловсролын төсвийн хэмжээ нь тухайн муж улс, ялангуяа орон нутгийн амьжиргааны түвшингээс шууд хамааралтай гэсэн үг юм. 2013 оны байдлаар орон нутагас ерөнхий боловсролд 270.6 тэрбум доллар хуваарилснаас 184.5 тэрбум нь татварын орлогоос, үүний 95.5% нь хөрөнгийн татварын орлогоос бүрджээ.

Дээрх гурван субъект боловсролын төсвийг санхүүжүүлэх хэмжээ нь муж тус бүрд харилцан адилгүй, хамгийн “баян” буюу амьжиргааны түвшин өндөр Мэрилэнд мужийн хувьд холбооны улсын Засгийн газраас 5.9%, муж улсаас 44.1%, орон нутаг 49.9% байхад, хамгийн “ядуу” буюу амьжиргааны түвшин доогуур Миссиссиппи мужийн хувьд холбооны улсын Засгийн газар 15.9%, муж улс 49.9%, орон нутаг 34.1% байдаг байна (Худалдааны хэлтэс, 2013).

2. Төсвийн хуваарилалт

Холбооны улсын Засгийн газраас ерөнхий боловсролын төсвийг хоёр замаар хуваарилдаг аж. Нэг нь холбооны улсын Засгийн газраас шууд орон нутагт, нөгөө нь мужийн Засгийн газраар дамжуулан хуваарилдаг байна. Энэ төсвийн дийлэнх нь өрхийн орлого бага, эмзэг

¹¹ *ad valorem tax*

бүлгийн өрхийн хүүхдүүдэд зориулсан нэмэлт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулагддаг байна. Холбооны улсын Засгийн газар 2013 оны санхүүгийн жилд 54.3 тэрбум доллароор ерөнхий боловсролыг санхүүжилснээс 91.7% буюу 49.9 тэрбумыг нь мужийн Засгийн газраар дамжуулан, үлдсэн хувийн шууд орон нутагт өгсөн байна (Хүн амын тооллогын хэлтэс¹²). Мужаар дамжуулан олгосон төсвийн 13.8 тэрбум доллар нь хүүхдийн өдрийн хоолны зардлыг¹³ санхүүжүүлэхэд зарцуулагджээ.

Муж улс ерөнхий боловсролын төсвийг олгохдоо санхүүжилтийн томъёо ашиглаж, тусгай хөтөлбөрүүдийг өөр аргаар санхүүжүүлдэг байна. 2013 онд мужийн Засгийн газар ерөнхий боловсролд 272.9 тэрбум доллар зарцуулсны 184.4 тэрбум буюу 67.5%-ийг санхүүжилтийн томъёогоор олгожээ. Үлдсэн хэсэг нь сургуулийн нэмэлт хөтөлбөр, тусгай хэрэгцээт болон мэргэжлийн боловсрол, сургуулийн автобус, орон нутгийн боловсролын удирдах байгууллага, багш ажилчид хөгжлийн хийгээд хөрөнгийн, мөн бусад зардалд хуваарилагджээ.

Орон нутгийн боловсролын төсвийн бүрдүүлэлтийн дийлэнх хувийг хөрөнгийн татварын орлого эзэлдэг байна. Үүнээс шалтгаалан орон нутгуудын ерөнхий боловсролын төсөвт ялгаатай байдал үүсдэг аж. Учир нь “баян” орон нутгийн хөрөнгийн татвар их тул тэр хэмжээгээр нэг хүүхдэд ногдох боловсролын зардал нь “ядуу” орон нутгийн нэг хүүхдэд ноогдох боловсролын зардлаас өндөр байдаг байна.

Тиймээс муж улсаас ерөнхий боловсролыг санхүүжүүлэхдээ орон нутаг хоорондын тэгш байдлыг хангах зарчмыг баримталдаг байна. Үүнд төсвийн бүрдүүлэлтийн¹⁴, хуваарилалтын¹⁵, зардлын зэрэг тэгш байдал¹⁶ багтдаг аж (Гармс, Гютри, & Пиерс, 1978¹⁷). Боловсролын төсөв бүрдүүлэлтийн, хуваарилалтын, зардлын зэрэг тэгш байдлыг хангахын тулд олон төрлийн нэмэлт санхүүжилтийн аргачлалыг ашигладаг байна.

Үүнд, жигд санхүүжүүлэх¹⁸, хувьсах зардлаар санхүүжүүлэх¹⁹, татварын зөрүүг багасгах²⁰, нийт зардлыг санхүүжүүлэх²¹, орон нутгийн төсвийн

¹² *US. Census Bureau*

¹³ *Child nutrition programs*

¹⁴ *wealth:power equalization*

¹⁵ *need equalization*

¹⁶ *cost equalization*

¹⁷ *Garms, Guthrie & Pierce*

¹⁸ *Flat grant program*

¹⁹ *Foundation program*

²⁰ *Guaranteed tax base program*

²¹ *Full state funding*

чадавхийг тэнцвэржүүлэх зэрэг аргачлал²² багтдаг ажээ. Жигд санхүүжүүлэх аргачлал нь бүх орон нутагт нэг хүүхдэд ногдох нэгэн ижил зардлыг хуваарилдаг бол хувьсах зардлаар санхүүжүүлэх аргачлал нь мужийн нэг сурагчид ногдох хамгийн бага зардал²³-ыг тогтоодог байна. Үүний дараа орон нутагаас орох хөрөнгийн татварын орлогын нэг хүүхдэд ногдох хэмжээ ба нэг хүүхдэд ногдох хамгийн бага зардал хоёрын зөрүүг мужаас санхүүжүүлдэг байна (Ким, 1993).

Ингэснээр ядуу орон нутаг мужаас авах татаас их бол, баян орон нутаг мужаас авах татаас бага болдог байна. Татварын зөрүүг багасгах аргачлал гэдэг нь боловсролын төсвийг орон нутагт хөрөнгийн татварын орлогоос бүрдүүлэхэд орон нутаг хооронд үүсэх боловсролын зардалд ялгаа үүсч байна гэж үзэн хөрөнгийн татвар²⁴-ын суурьтгэлцүүрийг тэнцвэртэй тогтоож орон нутгийн ерөнхий боловсролыг санхүүжүүлэх аргачлал юм (энэ өгүүлбэрийг хэд уншаад эс ойлгов) (Багш судлаачдад зориулсан хөтөлбөр, 2007²⁵). Үүнийг Орон нутгийн төсвийн чадавхийг тэнцвэржүүлэх тогтолцоо ч гэж нэрлэдэг. Нийт зардлыг санхүүжүүлэх аргачлал нь боловсролын зардлын тэгш байдлыг хангахын тулд орон нутгаас үл хамааран бүх сурагчдад адил хэмжээний зардлыг гаргах зорилготой. Хувьсах зардаар санхүүжүүлэх аргачлалыг 38, жигд санхүүжүүлэх аргачлал, нийт зардлыг санхүүжүүлэх аргачлалыг тус бүр 1, орон нутгийн төсвийн чадавхийг тэнцвэржүүлэх аргачлалыг 3 муж хэрэглэдэг бол 7 муж 2-3 төрлийн аргачлалыг хослуулан ашигладаг ажээ (Верстеген, 2011²⁶).

Мужаас орон нутагт боловсролын төсөв хуваарилахдаа ямар хүчин зүйлүүдийг харгалзан үзэж байгааг Санхүүжилт ба шударга байдал²⁷ (2013)-аас дэлгэрэнгүй үзэж болно.

Орон нутаг нэгж сургуульд төсвийг хуваарилахдаа сургуулийн санхүүжилтийн томъёо²⁸-г ашигладаг байна. Орон нутаг бүрийн ашиглаж буй томъёо ялгаатай ч, дараах 5 хүчин зүйлийг багтаасан байдаг аж. Үүнд, нэг сурагчид ногдох зардал, анги буюу боловсролын түвшин, сургалтын хөтөлбөрийн онцлог (мэргэжлийн боловсрол, гадаад хэлний сургалт, сургууль завсардсан хүүхдэд зориулсан нэмэлт сургалт г.м), сурагчийн онцлог (эмзэг бүлгийн, ангиас өөр үндсэн хэлтэй, хөгжлийн бэрхшээлтэй г.м), сургуулийн онцлог (сургуулийн хэмжээ буюу сурагчдын тоо бага сургууль)-ийг харгалзан нэмэлт санхүүжилт өгдөг байна. Эдгээр хүчин зүйлийг санхүүжилтын томъёонд ашиглахдаа жигнэсэн дунджийн арга²⁹-ыг ашигладаг байна.

Окленд³⁰болон Сиэтл³¹ орон нутаг сургуулийн төсвийг хуваарилахад ашигладаг жигнэсэн дунджийн коэффициентийг хүснэгт 2-т харуулав. Хүснэгтээс дээрх хоёр орон нутгийн хувьд хүчин зүйл тус бүрийн ангилал ялгаатай байгааг харж болно. Окленд нь зөвхөн бага сургуулийн эмзэг бүлгийн хүүхдэд болон англи хэл нэмж сурах шаардлагатай хүүхдэд, Сиэтл нь ахлах анги хүртэл нэмэлт санхүүжилт өгдөг байна. Мөн тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд нэмэлт санхүүжилтийг өгөхдөө Сиэтл орон нутаг хөгжлийн бэрхшээлийн зэрэглэлийг харгалзан үздэг аж.

Хүснэгт 2

Сургуулийн төсвийг хуваарилахад ашигладаг коэффициент

Хүчин зүйл	Окленд 1.0=\$3,380	Сиэтл 1.0=\$3,653	
Боловсролын түвшин	Бага сургууль	1.0	
	Дунд сургууль	1.0784	
	Ахлах сургууль	1.0926	
Эмзэг бүлгийн хүүхэд	Зөвхөн 1-5-р анги:	0.2	
		Бага 1-3:	0.087-0.099
		Бага 4-6:	0.126
		Дунд ахлах 6-12:	0.218-0.223

22 District power equalization systems:DPEs

23 minimum foundation program

24 tax base

25 Faculty Research Fellows Program

26 Versteegen

27 Funding Formulas and Fairness

28 formula funding of school

29 weight pupil approach

30 Oakland

31 Seattle

Англи хэл судлах шаардлагатай

Зөвхөн 1-5-р анги: 0.2

Бага 1-3: 0.27

Бага 4-6: 0.38

Дунд ахлах 6-12: 0.39

Тусгай хэрэгцээт боловсрол

Нэмэлт хөтөлбөр: 0.0097

Багштай ганцаарчлан ажиллах-нарийвчлаагүй: 0.0179-0.0189

Багштай ганцаарчлан ажиллах-нарийвчилсан: 0.0315-0.0328

Түвшин 2: 0.95

Түвшин 3: 1.04-2.64

Түвшин 4: 3.72-5.25

Эх сурвалж: Боловсролын Нөөцийн Стратеги¹

(Footnotes)

1 Education Resource Strategies (ERS)

Хүснэгт 3

Ерөнхий боловсролын төсвийн зарцуулалт /мян.доллар/

Зорнуулалт	Дүн	Эзлэх хувь
Хичээл, сургалт	321,311,163	60.56%
Үйлчилгээ	181,716,794	34.25%
Сурагчдад үзүүлэх үйлчилгээ	29,006,260	5.53%
Багшийн ажлыг дэмжих	24,230,278	4.63%
Удирдлага	9,848,908	1.93%
Сургуулийн удирдлага	28,280,609	5.33%
Барилга байгууламж	48,751,120	9.23%
Сургуулийн автобус	23,412,240	4.43%
Бусад	18,187,379	3.43%
Бусад эргэлтийн зардал	27,524,838	5.19%
Нийт	530,552,795	100.0

Эх сурвалж: US. Department of Commerce, 2013

ДҮГНЭЛТ

Судалгааг төсвийн бүрдүүлэлт, хуваариалт гэсэн үзүүлэлтээр авч, оролцогч субъектүүдийн үүрэг оролцоог авч үзлээ. Судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтийг хийж байна.

Нэг. АНУ нь боловсролын удирдлагын хуваарилалтыг дэмжих бодлого баримталдаг тул холбооны улс, муж улс, орон нутгийн гүйцэтгэх үүрэг нь ялгаатай байдаг байна. Үүнийг дагаад боловсролын төсвийг бүрдүүлэх, хуваарилах үйл явц нь дээрх гурван түвшинд хийгддэг байна. Холбооны улс нь ерөнхий боловсролын төсвийг хуваарилахдаа тэгш хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтыг хангахыг чухалчилдаг болох нь харагдлаа. Харин муж болон орон нутаг төсвийг хуваарилахдаа тэгш бүрдүүлэлт, тэгш хуваарилалтын зарчмыг баримталдаг байна.

Хоёр. Ерөнхий боловсролын төсвийн бүрдүүлэлтийг холбооны улс, муж улс, орон

нутаг гэсэн 3 түвшинд хийдэг ажээ. Холбооны улс ерөнхий боловсролыг санхүүжүүлэх төсвийн дийлэнх хувь орлогын татвараас бүрдэж байна. Харин муж ба орон нутаг ерөнхий боловсролын төсвийг олон төрлийн татвараас бүрдүүлдэг ч, дийлэнх хувь нь мөн л хөрөнгийн татварын орлогоос шууд хамааралтай байдаг байна. Ерөнхий боловсролын нийт төсвийн 90 гаруй хувийг муж, орон нутгаас бүрдүүлж байна. Үүнээс шалтгаалан орон нутаг хооронд үүсэх төсвийн тэгш бус байдлыг хуваарилалтын зарчмаар зохицуулдаг байна.

Гурав. Ерөнхий боловсролын төсвийн хуваарилалтыг мөн л холбооны улс, муж улс, орон нутаг гэсэн гурван түвшинд хийж байна. Холбооны улс нь ерөнхий боловсролын төсвийг муж улсаар дамжуулах, эсвэл шууд хуваарилах гэсэн хоёр замаар олгодог ажээ. Харин муж улсаас орон нутагт төсвийг хуваарилахдаа санхүүжилтийн томъёо ашиглах, мөн нэмэлт хөтөлбөрүүдийг

санхүүжүүлэх гэсэн хоёр аргыг хэрэглэдэг байна. Муж улс орон нутагт төсвийг хуваарилахдаа орон нутаг хоорондын төсвийн ялгааг багасгах зарчмыг баримталж, үүнийг хэрэгжүүлэхийн тулд олон төрлийн аргачлалыг ашигладаг байна. Орон нутаг сургуулийн төсвийг хуваарилахдаа жигнэсэн дунджын аргад тулгуурласан санхүүжилтийн томъёо хэрэглэдэг байна.

Дээрхээс харахад, АНУ нь ерөнхий боловсролын төсвийн бүрдүүлэлтийг хуулиар зохицуулж, бүрдүүлэлтийн эх үүсвэрийг орлогын болон хөрөнгийн татвараас бүрдүүлж байна. Энэ нь ерөнхий боловсролын төсвийн эх үүсвэрийн аюулгүй байдлыг хангаж буй хэрэг юм. Хөрөнгийн татварын эх үүсвэр нь орон нутаг хооронд нэг хүүхдэд ногдох боловсролын зардлын тэгш бус байдлыг дагуулдаг тул үүнийг тэгш хуваарилалтын зарчмаар шийдвэрлэж байна. Энд бүрдүүлэлтийг тэгш байх зарчмаар хуваарилах, зарцуулалтыг тэгш байх зарчмаар хуваарилах зэрэг олон аргыг ашиглаж байна. АНУ-ын жишээнээс харахад, манай улс ерөнхий боловсролын төсвийн эх үүсвэрийн аюулгүй байдлыг хуулиар зохицуулах, тэгш хуваарилалтын зарчмыг улс, орон нутгийн түвшинд харгалзан үзэх нь чухал юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг. (2013). Боловсролын салбарын тойм судалгаа.
- Education Law Center. (2013). Funding Formulas and Fairness. What Pennsylvania Can Learn From Other States' Education Funding Formulas. From: http://www.elc-pa.org/wp-content/uploads/2013/02/ELC_schoolfundingreport.2013.pdf
- ERS(____). Fair Student Funding Summit: Conference Proceedings and Recommendations for Action. Education Resource Strategies.
- Faculty Research Fellows Program(2007). School Funding Formulas: What Works and What Doesn't? Lessons for California.
- Garms, W. I., Guthrie, J. W., Pierce, L. C.(1978). *School Finance: The Economics and Politics of Public Education*. Prentice-Hall.
- Kaplan, L. S., Owings, W. A. (2010). *American education: Building a common foundation*. Wadsworth Publishing
- Kim, Ee-gyeong. (2014). Are Regulations a Precondition of Government Financial Support: An Analysis of Secondary Private Schools in the United States. *Korean Education Inquiry*, 32(1), 113-135.
- Kim, Yong-chul. (1993). Educational Finance Distribution Policy in the United State. *The Journal of Economics and Finance of Education*, 2(1), 49-80.
- Ross, K. R., & Levacic, R. (1999). Needs Based Resource Allocation in Education: via formula funding of school. UNESCO.
- Verstegen, D. A. (2011). Public Education Finance Systems in the United States and Funding Policies for Populations with Special Educational Needs. *Education Policy Analysis Archives*, 19(21).
- US. Department of Commerce. (2013). Public Education Finances: 2013.
- National Center for Education Statistics: <https://nces.ed.gov/>
- US. Census Bureau: http://www.census.gov/http://factfinder.census.gov/faces/tableservices/jsf/pages/productview.xhtml?pid=SSF_2013SSF013&prodType=table